



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/90

Бат-Өлзий сум

Түгээмэл тархацтай материал ашиглах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.18, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын хэвлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хужирт-Бат-Өлзий чиглэлийн хатуу хучилттай 49 км авто зам, зам барих ажилд шаардагдах хайргыг Урд агуйтын хаяа, Бөхөн шарын зүүн үзүүр (46°50'05.9"N 102°17'10.0"E, 46°50'06.5"N 102°17'12.4"E, 46°50'05.0"N 102°17'11.1"E, 46°50'05.9"N 102°17'10.0"E)-ээс авч ашиглахыг "Мотор сервис" Хязгаарлагдмал хариуцлагатай компани-д зөвшөөрсүгэй.

2. Хайрга ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Янжиндулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН